



МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-3

2014 он

2014-2015 оны хичээлийн жилийн МУИС-ийн бакалаврын хөтөлбөрийн элсэлтийн мэдээлэл

2014-2015 оны хичээлийн жилийн элсэлт юугаараа онцлог байв?

- 2014-2015 оны хичээлийн жилд МУИС өдрийн бакалаврын хөтөлбөрт 3655 оюутан элсүүлэх квоттой байсан бөгөөд нийт 3634 оюутан элсэж элсэлтийг 99.4 хувь бүрэн авлаа.
- Өмнөх жилүүдээс элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо эрс өссөн. 2013 онд дундаж оноо 612 оноо байсан бол 2014 онд 648 оноо болж өслөө.
- Элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноотой болон улсын ба олон улсын олимпиадад байр эзэлсэн элсэгчдийн тоо өмнөх жилүүдээс өссөн байна.
- Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 20 гаруй хувиар буурсан нь элсэгчдийн тоонд сөргөөр нөлөөлөх магадлалтай байв.
- 2014 оны 9 дүгээр сарын 5-ны байдлаар ШУТИС, АШУУИС (хуучнаар ЭМШУИС), МУБИС, ХААИС зэрэг Монгол улсын тэргүүлэх төрийн их дээд сургуулиудын элсэлт 60-89 орчим хувьтай байна.

Элсэлтэд нөлөөлөх сөрөг болон эерэг хүчин зүйлс байсан уу?

- МУИС-ийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт: 14 бүрэлдэхүүн сургуулиас 5 бүрэлдэхүүн сургууль болсон нь олон нийтэд төдийлөн танигдаагүй байлаа,
- Хөтөлбөрийн шинэчлэл: 170 гаруй бакалаврын хөтөлбөрөөс 70 индекс бүхий бакалаврын зэрэг олгох хөтөлбөр боловсруулсан,
- Ерөнхий суурь хичээл: 8 үндсэн чиглэлээр 94 хичээл бүхий 100 хувь сонголтын тогтолцоог анхлан нутагшуулсан,
- Шинэ элсэгчийг тодорхой нэр заасан мэргэжилд бус харин бакалаврын хөтөлбөрт элсүүлсэн: элсэгч МУИС-ийн бүрэлдэхүүн сургуульд элсэн орж "ерөнхий суурь" хичээлээс 30-аас багагүй багц цаг судалсаны эцэст сурлагын голч оноо, ЭЕШ-ын дундаж оноо зэрэг үзүүлэлтүүдээр эрэмбэлэгдэн жагсаж мэргэжлийн хөтөлбөрөө сонгох боломжтой болсон.

Элсэгчдийн тоо болон чанар буурах эрсдэлээс сэргийлж ямар арга хэмжээ авсан бэ?

- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2014 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх журмыг шинэчлэн боловсрууллаа.
- Энэ журмын дагуу 1. МУИС-д элсэгчид тодорхой мэргэжлийн хөтөлбөрт бус харин бүрэлдэхүүн сургуульд элсэх, 2. Элсэгч өөрийн өгсөн элсэлтийн ерөнхий шалгалтуудаас сонгон тооцуулах боломжтой болсон, 3. Бүртгэлийн босго оноог БШУЯ-наас заасан түвшинд барьсан зэрэг нь 2014 оны элсэлтийг бүрэн авахын зэрэгцээ элсэгчдийн чанарыг сайжруулах боломж олгов.
- Хөдөө орон нутгаас авах элсэлтийг хариуцан зохион байгуулдаг Монголын их дээд сургуулиудын Консорциумтай зөвшилцөх замаар холбогдох журам зааварт МУИС-ийн элсэлтийн бодлогыг тусгав.

- Элсэлтийн журмын танилцуулгыг видео шторк, электрон болон хэвлэмэл хэлбэрээр хийж цахим хуудас зэргээр өргөн сурталчилсан. Үзнэ үү: www.num.edu.mn. МУИС-ийн бакалаврын элсэлт
- Их дээд сургуулийн элсэлтийн үзэсгэлэн яармагт оролцохын хамт "МУИС-ийн элсэлт" нээлттэй өдөрлөгийг их сургууль даяар зохион байгуулав.
- Хөдөө орон нутгийн элсэгчдэд МУИС-ийн элсэлт, хөтөлбөрүүдийг танилцуулах үүднээс олон төгсөгч бүхий 10 гаруй аймгуудад МУИС-ийн эрдэмтэн багш нарыг томилон ажиллуулав.

Өргөдлөөр бус нээлттэй онлайн бүртгэлийн системээр элсэлтээ бүрэн авлаа:

- Бүртгэлийн системийн тусламжтайгаар 100 хувь онлайн хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд өргөдөл болон хандиваар оюутан элсүүлээгүй,
- Жил жилийн намар босго оноогоо бууруулдаг, өргөдөл хандиваар "нэмэлт элсэлт" зохион байгуулдаг уламжлалаас бүрэн татгалзаж сурах эрх аваад түүнээ баталгаажуулаагүйгээс болж үлдсэн 200 гаруй хуваарьт 2000 шахам элсэгчдийг онлайн бүртгэн өрсөлдүүлж гарсан оронг бүрэн нөхсөн.

Ирэх 2015-2016 онд бакалаврын элсэлт буурах эрсдэл байгаа эсэх түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?


- Монгол улс 12 жилийн ерөнхий боловсролын тогтолцоонд шилжиж буйтай холбогдож 2015 оны хавар дунд сургуулийн төгсөгчдийн тоо 2014 онтой харьцуулахад даруй 50 орчим хувиар буурах магадлалтай байна.

Иймээс МУИС нь

- МУИС-ийн бакалаврын элсэлтийн тоог зах зээлийн багтаамж, эрэлт хэрэгцээтэй уялдуулан зөв тогтоож, магистр докторын хөтөлбөрт элсэгчдийн тоог нэмэгдүүлэх,
- Улс орны хөгжилд зайлшгүй шаардлагатай атлаа элсэгч, эрэлт багатай хөтөлбөрт элсэх хүсэлтэй сурлага сайтай элсэгчдийг дэмжих тэтгэлэг бий болгох, өнөөдөр олгож байгаа тэтгэлгийг дээрх хөтөлбөрүүд рүү хандуулах, төрийн санхүүжилтээр сургадаг тогтолцоог бүрдүүлэх
- Үндсэн мэргэжлийн хөтөлбөрүүдийг сурталчлах замаар оюутан суралцагсдыг бусдыг даган хошуурч мэргэжлээ сонгодог бус өөрийн сонирхол, авьяас чадвартаа түшиглэн мэргэжлээ ухамсартай сонгодог соёлыг хэвшүүлэх,
- Багшийн хөтөлбөрт суралцах ЭЕШ-ын оноо өндөр элсэгчдэд Засгийн газрын тэтгэлэг олгох асуудлыг холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх,
- Хос болон хавсрага мэргэжлийн хөтөлбөрүүдийг хөгжүүлэх замаар оюутан суралцагсдад сурч байгаа хугацаандаа хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх, хөрвөх чадвараа нэмэгдүүлэх боломж олгож, МУИС-ийн сургалтын давуу байдлыг олон нийтэд ойлгуулан таниулах зэргээр болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж байна.

МУИС, Сургалтын нэгдсэн алба

Хичээлийн байр, оюутны байрны байршил



МУИС-ИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА

МУИС-ийн хичээлийн I байр,
Их Сургуулийн гудамж - 1, Бага тойруу,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

<http://num.edu.mn>

our@num.edu.mn,